



## НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар Б/77

Улаанбаатар хот

### Цалин тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3, 16.5.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүнийг батлах тухай” 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2007 оны “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 354 дүгээр тогтоол, 2018 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай” 382 дугаар тогтоол, 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 24 дүгээр тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны Б/257, Б/258 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн 9 дүгээр хорооны улсын бүртгэгч Жигжидийн Бямбарагчаагийн албан тушаалын цалинг ТЗ-6-2-оор, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар, Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ганбаатарын Чанаганингарын албан тушаалын цалинг ТЗ-6-2-оор, зэрэг дэвийн нэмэгдлийг дэс түшмэлийн дөтгөөр зэрэг 18 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 хувиар тус тус тогтоосугай.

2. Албан хаагчийн цалин, хоол унааны нөхөх төлбөрийг зохих журмын дагуу тооцон, 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс бодож олгохыг Захиргааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч Б.Эрдэнэчимэгт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттөмөрт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.АНХНЫБАЯР

001140500767